

“ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах зорилгоор сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй ажиллах ур чадварыг сайжруулах дохионы хэлний анхан, дунд, ахисан шатны сургалтад улсын бүртгэгч Э.Оюунбат, Н.Алтанцэцэг, Ц.Оюунсүрэн нарыг хамруулсан. Мөн тайлангийн хугацаанд шинээр томилогдсон улсын бүртгэгчийг хамруулахаар судалгааг гаргаад байна.

Тус хэлтэс нь төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний 26 албан хаагч, хөдөлмөрийн гэрээний дагуу гэрээт албан хаагч 4 ажилладаг бөгөөд гэр бүлийн гишүүдийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний судалгааг гаргаж үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэнээр бүртгэгдсэн иргэн байхгүй байна.

УБЕГ-ын даргын баталсан 2019 оны А/685 дугаар “Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт батлах тухай” тушаалын 7 дугаар зүйл 7.1.4, 9 дүгээр зүйл 9.1.5-д заасныг дагуу Хөгжлийн бэрхшээлтэй иргэн улсын бүртгэлийн үйлчилгээг тэгш авах боломжийг бүрдүүлж зориулалтын тусгай цонх үйлчилгээний зааланд ажиллуулж, ойрын харааны шил, бүртгэлийн зөвлөгөө мэдээлэл танилцуулсан тараах материалыг ARIAL MON 16 үсгийн фонтоор хэвлэн байршуулан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дугаар харгалзахгүйгээр үйлчилгээ үзүүлэн ажиллуулж байна.

